

Монгол Улсын Газар Хөдлөлтийн Гамшгаас Хамгаалах Чадавхийг Бэхжүүлэх Төсөл

Төслийн танилцуулга

Монгол Улсын баруун болон баруун өмнөд хэсэгт 8 магнитудын хүчтэй эх газрын голомт бүхий газар хөдлөлт нэлээн олон удаа бүртгэгдсэн байдаг. Түүнчлэн, хүн амын тал хувь нь оршин суудаг Улаанбаатар хотын ойр орчимд байрлах идэвхтэй хагарлуудын идэвхжил нь буурахгүй байгааг ажиглалт, судалгаагаар тогтоосон.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулга мөрдөгдөж эхэлснээр гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны ач холбогдлын талаарх олон нийтийн ойлголт нэмэгдэн дээшилж байна. Нөгөөтэйгүүр, гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээ, тэр дундаа газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхийг цогцоор нь сайжруулан бэхжүүлэх нь ОБЕГ болон бусад холбогдох байгууллагуудын нэн тэргүүнд хурдацтай хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний нэг болоод байна.



Монгол Улсын Засгийн газар Японы Засгийн газраас газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн төсөл хэрэгжүүлэх хүсэлт тавьж, урт хугацааны туршид Японы хуримтлуулсан гамшгийн талаарх туршлага ба мэдлэгт үндэслэн Монгол Улсын газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах чадавхийг бэхжүүлэх зорилгоор бид бүхэн уг техникийн хамтын ажиллагааны төслийг Онцгой Байдлын Ерөнхий Газартай хамтран хэрэгжүүлж байна.



Ерөнхий зорилго

Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэл буурна.

Төслийн зорилго

Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх замаар гамшгаас хамгаалах Онцгой Байдлын Ерөнхий Газар (ОБЕГ)-н чадавхи бэхжинэ.

Төслийн үр дүн

Үр дүн 1: Монгол Улсын гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг цуглуулах чадавхи болон байгууллага хоорондын хамтын ажиллагааг зохицуулах чадавхи сайжрана.

Үр дүн 2: Тэсвэржилтийн үнэлгээ болон барилга байгууламжийн газар хөдлөлтийн тэсвэржилт хариуцсан төрийн байгууллагын ажилтнуудын чадавхи дээшилнэ.

Үр дүн 3: Гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгаа хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулагдаж, хэрэгжинэ.

Төслийн хугацаа: 3 жил

2016 оны 12-р сар

2020 оны 1-р сар


Төсөл Хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалт




ЯПОНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛЛАГА



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР



БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ



БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМ



МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗАР



НИЙСЛЭЛИЙН ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГАЗАР